



# **ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ**

---

**2021 оны 39 болон 40 дэх долоо хоног**

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 11-р сарын 01-нээс 11-р сарын 11-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 17 дахь дугаарыг хүргэж байна. Энэ удаагийн дугаарт i) БНХАУ-ын эрчим хүчний хямралын тухай, ii) БНХАУ-ын эдийн засагт бий болсон голлох өөрчлөлтүүд болон түүхий эдийн зах зээлд гарсан өөрчлөлтийг тоймлон эмхэтгэв.

### 1 БНХАУ-ын эрчим хүчний хямралын тухай

#### *Эрчим хүчний хямралын эхлэл*

- Хөгжингүй орнуудын эдийн засаг 2021 оны 2-р улирлаас эрчимтэй сэргэж, улмаар БНХАУ-ын аж үйлдвэрлэл, үүнийг дагасан эрчим хүчний эрэлт болон эрчим хүчний гол орц болох нүүрсний эрэлт огцом нэмэгдсэн. Харин нийлүүлэлт талаас БНХАУ-ын Засгийн газраас нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах зорилт<sup>1</sup>-ын хүрээнд дотоодын нүүрсний үйлдвэрлэлд тавих стандартаа чангаруулснаар БНХАУ-ын дотоодын нүүрсний нийлүүлэлт буурчээ. Улмаар нүүрсний эрэлт нийлүүлэлтээсээ хэт давж, нүүрсний үнэ сүүлийн саруудад огцом өсөөд байна. Энэ нь БНХАУ-ын эрчим хүчний үйлдвэрлэл буурахад нөлөөлж байна. БНХАУ-ын эрчим хүчний хямрал 2021 оны 7-р сараас хойш үргэлжилж, 2021 оны 8-р сард гэхэд БНХАУ-ын 31 мужаас 20 муж нь эрчим хүчээ хэмнэх

болсон бөгөөд 10-р сараас зарим мужид аж үйлдвэрлэл зогсох эрсдэлд орсон тул өрхийн цахилгааны хэрэглээг хязгаарлаж байна.

#### *Эрчим хүчний хямралын нийлүүлэлтийн гинжин сүлжээнд үзүүлж буй нөлөө*

- БНХАУ олон улсын нийлүүлэлтийн гинжин сүлжээнд гүнзгий нэвтэрсэн тул БНХАУ-ын эрчим хүчний хомсдол нь тус улсын аж үйлдвэрлэл, экспорт, цаашлаад дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд сөргөөр нөлөөлж байна.
- Эрчим хүчний хэрэглээ хамгийн өндөртэй ган, хөнгөн цагаан, цементийн үйлдвэрлэлүүд 2021 оны 9, 10-р саруудад 15 хүртэл хувиар агшсан бөгөөд эрчим хүчний хямралаас үүдэлтэй үйлдвэрлэлийн доголдол ирэх саруудад үргэлжлэх төлөвтэй байна.

<sup>1</sup> БНХАУ-ын Коммунист намын төв хорооноос 10-р сарын 24-нд БНХАУ-ын 2060 он хүртэл нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах төлөвлөгөө бүхий баримт бичгийг нийтэлсэн. Уг

баримт бичигт БНХАУ нүүрсхүчлийн хий ялгаруулалтаар 2030 он гэхэд хамгийн дээд цэгт хүрч, түүнээс цааш бууруулан 2060 он гэхэд ялгарлын хэмжээг тэгд хүргэх зорилт тавьсан.



- БНХАУ-ын ургац хураалтын улирал (9-11-р сар)-ын үеэр эрчим хүчний хямрал нүүрлэсэн нь дэлхийн хүнсний нийлүүлэлтийн гинжин сүлжээг эрсдэлд оруулав. БНХАУ нь дэлхийн хөдөө аж ахуйн хамгийн том үйлдвэрлэгч бөгөөд эрдэнэ шиш, шар буурцаг, газрын самар, хөвөн зэргийн ургац хураах, боловсруулах процесст хүнд сорилттой тулгарч байна. Жишээлбэл, шар буурцагас тос болон тэжээвэр амьтны тэжээл гаргаж авдаг боловсруулах үйлдвэрүүд эрчим хүчний хязгаарлалтын улмаас үйлдвэрлэлээ хумьж байна.
- БНХАУ-ын цаасан хайрцаг, сав баглааны үйлдвэрлэл 9,10-р сард 10-15 хувиар буурснаас аль хэдийнээ дэлхийн цаасны хомсдолтой байсан нөхцөл байдал улам хүндрэв.
- БНХАУ-ын ноос, ноолуурын үйлдвэрлэл өмнөх 11-р сарын эхний долоо хоногт гарцаа хэвийн үеэс 40 хувь бууруулснаар Австралийн ноосны эрэлт огцом унав.
- БНХАУ-ын гар утасны чип үйлдвэрлэгч хамгийн том компани болох “ASE технологи” үйлдвэрлэлээ хэд хоногоор зогсоосноор гар утас үйлдвэрлэл чипний дутагдалд оров.
- БНХАУ-ын автомашины хагас дамжуулагч болон чипний үйлдвэрлэл тасалдсан нь автомашины үйлдвэрлэлийн шат дамжлагад саатал бий болгож байна.

#### *Засгийн газрын оролцоо*

- БНХАУ-ын дотоодын эрчим хүчний нүүрсний үнэ 10-р сард тонн тутамд 2,000 юань даваад байсан бол БНХАУ-ын Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хорооноос нүүрс болон эрчим хүчний үнэ хэт хөөрөгдөхөөс сэргийлэх зорилгоор 11-р сарын эхээр нүүрс

үйлдвэрлэгчидтэй уулзаж, нэг тонн эрчим хүчний нүүрсний үнийг өвлийн улиралд 1,200 юань буюу ойролцоогоор 188 ам.доллараас хэтрүүлэхгүй байх үнийн таазыг тогтоов.

- БНХАУ-ын эрх баригчид дотоодын нүүрсний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого баримталж, компаниудад нийлүүлэлтээ нэмэгдүүлэхийг даалгасан. Улмаар БНХАУ-ын дотоодын нүүрсний үйлдвэрлэл 11-р сарын 8-ны өдрийн байдлаар 11.9 сая тоннд хүрсэн нь өмнөх сарын мөн үеэс өдрийн 1 сая тонноор нэмэгдсэн дүн болж байна (үйлдвэрлэлийн потенциал түвшний 80 хувьтай ажиллаж байна). Үүний хажуугаар БНХАУ нүүрсний импортоо мөн нэмэгдүүлж байна. Тухайлбал, БНХАУ-ын нүүрсний импорт 9-р сард жилийн 76 хувиар, 10-р сард жилийн 97 хувиар тус тус өсжээ.
- Мөн БНХАУ-ын Засгийн газраас эрчим хүч үйлдвэрлэгчдийг үнээ нэмэхийг зөвшөөрснөөр эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн байна. Эдгээр арга хэмжээг авснаар энэ оны 11-р сараас эрчим хүчний нүүрсний үнэ буурч, эрчим хүчний нийлүүлэлт сэргэж, доголдол багасч эхлээд байна.

#### *Цаашдын төлөв*

- Эрчим хүчний хямралын нөхцөл байдал 11-р сараас дээрдэж байгаа хэдий ч эрчим хүчний хэрэглээ нэмэгддэг өвлийн улирал эхэлж байгаа (эрэлт 1-р сард хамгийн өндөр) тул эрчим хүчний хомсдолтой нөхцөл байдал 2022 оны хавар хүртэл үргэлжилж болзошгүй байна. Хэрэв эрчим хүчний хямрал үргэлжилбэл БНХАУ-ын үйлдвэрлэл, экспортоор зогсохгүй нийлүүлэлтийн гинжин сүлжээгээр дамжин дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Мөн одоо үүсээд буй нөхцөл байдал нь БНХАУ-ын эрчим

хүчний хүчин чадал нь дунд хугацаанд тогтвортой эдийн засгийн өсөлтийг

*Эх сурвалж:*

1. South China Morning Post, [China's state grid says electricity supplies have stabilised after power crunch, but winter shortages still a risk](#)
2. Bloomberg, [China's Energy Crisis Is Hitting Everything From iPhones to Milk](#)
3. News24, [China's coal imports double after energy crisis](#)
4. OPEC, [21st OPEC and non-OPEC Ministerial Meeting concludes](#)

дэмжихэд хангалтгүй байж болзошгүйг харуулж байна.

5. BEA, [Gross Domestic Product, Third Quarter 2021 \(Advance Estimate\)](#)
6. Financial Times, [China manufacturing slows as property and energy woes hit economy](#)
7. Financial Times, [Global investors turn cautiously optimistic on China](#)
8. Financial Times, [Evergrande: the bond and interest payment](#)
9. Financial Times, [China's coal miners commit to cut prices after state intervention](#)

## 2

## БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

*Эдийн засгийн голлох индексүүдийн өөрчлөлт*

- **Эрчим хүчний хямрал, үл хөдлөх салбарын уналт, түүхий эд материалын үнийн өсөлт зэргээс шалтгаалж БНХАУ-ын боловсруулах салбар 10-р сард дахин агшив.** Тодруулбал, 9-р сард 49.6 байсан боловсруулах салбарын PMI 10-р сард 49.2-д хүрч буурсан бөгөөд үүнд нийлүүлэлтийн болон эрэлтийн аль аль хүчин зүйлс нөлөөлж байна. Нийлүүлэлт талаас компьютерын чипний хомсдол, логистикийн асуудал, эрчим хүчний хямрал, КОВИД-19 цар тахлаас сэргийлэх зорилготой хөл хорио зэрэг нь голлон нөлөөлж байна. Харин эрэлт талаас санхүүгийн хүндрэл болон засгийн газрын тогтоосон дүрэм журмаас шалтгаалж үл хөдлөх салбарын эрэлт төдийлөн сэргээгүй байна.
- **Зарим хөрөнгө оруулагчдын итгэл сэргэснээр БНХАУ-ын хөрөнгийн зах зээл сэргэх хандлага ажиглагдаж байна.** Тухайлбал, 3 сарын өмнө цахим аюулгүй байдлын тухай дүрэм гаргасан нь БНХАУ-ын хөрөнгийн захад сөргөөр нөлөөлж, тогтворгүй байдал үүсгэж

байсан бол одоо Фиделити, Голдмэн Сакс зэрэг хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж байна. Шинжээчид “БНХАУ-ын Коммунист намын 20-р конгрессын хурал 2022 оны 11-р сард зохион байгуулагдах тул БНХАУ-ын талаас хөрөнгийн захыг тогтворжуулж, хөрөнгийн зах сэргэнэ” гэсэн хүлээлттэй байна. Гэвч Кредит Свис, Коплей Фонд Ресөрч-ийн судлаачдын үзэж байгаагаар БНХАУ-ын хөрөнгийн захыг сэргэж байгаа гэж харахад арай эрт байна гэж дүгнэжээ.

- **Эвергранд ам.доллараар илэрхийлсэн бондын эргэн төлөлтийн дарамтад орсон хэвээр байгаа бөгөөд 10-р сард дефолт зарлахын өмнөхөн 83.5 сая ам.долларын бондын хүүг шилжүүлжээ.** Хэдийгээр Эверграндад энэ онд хугацаа нь дуусч байгаа бонд байхгүй боловч 2022 оны 3, 4-р сард бондын эргэн төлөлт хийх шаардлагатай байна. Сүүлийн мэдээгээр 2022 оны 6-р сарын эцэст 13.6 тэрбум долларын өрийг эргэн төлөх хуваарьтай байгаа юм */Дор Хүснэгт.1-д зээлийн хүүгийн болон эргэн төлөлтийн үндсэн дүнг харуулав/.*

Хүснэгт 1. Эверграндын зээлийн эргэн төлөлтийн график (Энд: цэнхэр- зээлийн хүү, улаан – үндсэн төлбөр)

<b>2021.11.6</b>	<b>2021.12.28</b>	<b>2022.1.22</b>	<b>2021.1.24</b>	<b>2021.2.14</b>	<b>2022.3.23</b>	<b>2022.4.11</b>
82.5сая \$	255.2сая \$	117.5сая \$	235сая \$	2.1сая \$	2.1тэрбум \$	1.5тэрбум \$
<b>2022.5.6</b>	<b>2022.6.28</b>	<b>2022.7.22</b>	<b>2022.7.24</b>	<b>2022.8.14</b>	<b>2022.9.29</b>	<b>2022.10.11</b>
82.5сая \$	255.2сая \$	117.5сая \$	235сая \$	2.1сая \$	45.2сая \$	79.3сая \$
<b>2022.10.24</b>	<b>2022.11.6</b>	<b>2022.12.28</b>				
2.1тэрбум\$	727.5сая \$	255.2сая \$				

Түүхий эдийн зах зээлд гарсан өөрчлөлт

- БНХАУ-ын Засгийн газраас эрчим хүчний нүүрсний үнэ тогтворжуулах бодлогын нөлөөгөөр нийлүүлэлт нэмэгдэж, эрчим хүчний нүүрсний үнэ хурдацтай буурав. Голлох нүүрсний олборлогчдын нийлүүлэлт ийнхүү нэмэгдсэн ч Ордос, Өвөр Монголын нүүрсний олборлолт нүүрсний борлуулалтын квотоос шалтгаалж ялимгүй хязгаарлагдав.
- Эрчим хүчний нүүрсний голлох хэрэглэгчид нүүрсний үнэ цаашид дахин буурахыг хүлээж, төдийлөн эрэлтээ нэмэгдүүлэхгүй байна. Тухайлбал, цахилгаан станцууд одоогоор нүүрсний нөөцөө бүрэн татаагүй бөгөөд цаашид нүүрсний үнэ дахин буурахыг хүлээж, тэр үед нөөцлөхөөр хүлээж байна. Гэвч цахилгаан станцуудад нүүрсний хэрэглээ огцом нэмэгдэх үе (11-р сарын дунд үеэс сүүл үе хүртэл)-ийг хүртэлх нүүрсний нөөцөө нэмэгдүүлэхэд богино хугацаа үлдээд байна. Богино хугацаанд цахилгаан станцууд нүүрсний нөөцөө нэмэгдүүлэх шаардлагатай, мөн уг зах зээл нийлүүлэлтийн хомсдолтой байгаа тул эрчим хүчний нүүрсний эрэлт өндөр байхаар байна.
- Бодлогын зохицуулалт чангарч байгаа энэ үед үйлдвэрүүд нүүрсээ үнийн таазнаас ялимгүй бага үнээр борлуулах

хүлээлттэй байна. Цаашид голлох үйлдвэрүүдийн нүүрсний олборлолт, зохицуулалтаас шалтгаалж нүүрсний үнэ өөрчлөгдөх төлөвтэй байгаа юм.

- Коксжих нүүрсний эрэлт, нийлүүлэлт өөрчлөлтгүй байж, бодлогын нөлөө бага байснаар коксжих нүүрсний үнэ өнгөрсөн 7 хоногт тогтвортой байсан талаар SXcoal мэдээллээ. Тухайлбал, 10-р сарын 29-ний байдлаар Хэбэй мужид 1 тонн коксжих нүүрсний үнэ 4,260 юань буюу 665.9 орчим ам доллар, Шанси мужид 4,060 юань буюу 635 орчим ам.доллар байсан нь өмнөх долоо хоногтой ижил үнэ юм. Харин боомтуудын хувьд фьючерсийн үнэ өдрийн лимитээс давж буурсан тул худалдан авагчид идэвхгүй байлаа.
- БНХАУ-ын коксжих нүүрсний үйлдвэрийн нөөц 10-р сарын 29-ний байдлаар өмнөх оны мөн үеэс 30.3 хувиар бага буюу 11.5 сая тонн байна. Мөн гангийн үйлдвэрүүдийн коксжих нүүрсний нөөц өмнөх оны мөн үеэс 24.8 хувиар бага буюу 8.97 сая тонн байна.
- Эрчим хүчний болон гангийн үйлдвэрлэлийн хязгаарлалтаас шалтгаалж гангийн нийлүүлэлт 11-р сард буурахаар байна. Нүүрс болон гангийн фьючерс зах сул байгаа, ашиг буурсан зэргээс коксжих нүүрсний үйлдвэрлэл, борлуулалт аль аль нь буурч байна.



- Зүүн хойд муж, Шаньдун муж, Хэбэй мужуудын боомтуудад байгаа Австралийн нүүрсийг импортлох зөвшөөрөл олгожээ. Гэвч цаашид Австралийн нүүрсийг хэрхэх талаар бодлогын эрсдэл өндөр тул худалдан авагчид шууд нөөцөө бүрдүүлэлгүй, нөхцөл байдал илүү тодорхой болохыг хүлээсэн байдалтай идэвхгүй байна.
- Цаашид нүүрсний нийлүүлэлт нэмэгдэж эрэлт буурах төлөвтэй байгаа бөгөөд нүүрсний үнэ буурахаар байна. Тодруулбал, коксжих нүүрсний голлох хэрэглэгчид үйлдвэрлэлээ бууруулах, Австралийн нүүрсний импортыг зөвшөөрч байгаа зэргээс шалтгаалж нүүрсний үнэ буурах хандлага давамгайлж байна.

#### *Монголын нүүрсний импорт*

- Цар тахлаас шалтгаалж Монголын нүүрсний импорт хязгаарлагдсан хэвээр байна. Тодруулбал, Эрээн хот болон Сэхэ боомтууд хаалттай хэвээр байгаа бол 10-р сарын 29-ны долоо

хоногийн байдлаар Гашуунсухайт боомтоор нэвтэрсэн ачааны машины хоногийн дундаж тоо 200-тай байна. 10-р сарын 30-ны өдөр 219 ачааны машин нүүрс Гашуунсухайт боомтоор гаргажээ.

- Голлох хэрэглэгчид нь төдийлөн идэвхгүй байснаас шалтгаалж Монголын нүүрсний үнэ буурав. Гашуунсухайт боомтод 1 тонн коксжих нүүрсний үнэ 2,810 юань буюу 493.2 ам.долларт хүрсэн нь өмнөх 7 хоногоос 100 юань буюу 15.6 ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Харин Сэхэ боомтод 1 тонн коксжих нүүрсний үнэ 2,000 юань буюу 312.6 ам.доллар байсан нь төдийлөн өөрчлөгдөөгүй дүн юм.

#### *Эх сурвалж:*

1. *Weekly report of 12<sup>th</sup> November 2021, SxЫЧcoal*
2. *Evergrande: The bond and interest payment, Financial Times*

3

**МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ**

Бодит гүйцэтгэл							
	Үнэ (\$) 2021/11/12	Өөрчлөлт					Товч тайлбар
		өдрийн	7 хоногийн	сарын	оны эхнээс	жилийн	
<b>Зэсийн үнэ</b>	9,сд633.5	1.1%	2.1%	0.9%	22.6%	39.9%	Зэсийн үнэ 11-р сарын 11-ний байдлаар 9,633.5 долларт хүрч нэмэгдлээ. Зэсийн эрэлт нийлүүлэлтээс давж, зэсийн нөөц 11-р сарын хувьд 1,974 оноос хойш хамгийн бага түвшинд хүрснээс шалтгаалж зэсийн үнэ өмнөх оны мөн үеэс 40 орчим хувиар өслөө.
<b>Төмрийн хүдрийн үнэ</b>	93.6	1.6%	-3.6%	-28.1%	-42.9%	-23%	Гангийн үйлдвэрлэлийн хоригоос шалтгаалан төмрийн хүдрийн эрэлт буурсаар байна. БНХАУ-ын төмөр, гангийн холбооноос өдрийн гангийн үйлдвэрлэлийн хэмжээг 2.34 сая тонн байна гэж тооцоолж байгаа (10-р сард 72.5 сая тонныг үйлдвэрлэсэн) нь 2017 оны 12-р сараас хойш хамгийн бага үзүүлэлт болж байна гэж мэдээлэв. Ийнхүү гангийн үйлдвэрлэл буурч байгаагаас шалтгаалж төмрийн хүдрийн эрэлт буурч, үнэ нь 11-р сарын 11-ний өдрийн байдлаар өмнөх оноос 23 хувиар буурч 93.6 долларт хүрэхэд нөлөөллөө.
<b>Алтны үнэ</b>	1,859	-0.2%	3.7%	6.0%	-2.1%	-0.4%	11-р сарын 11-ний байдлаар нэг унц алтны үнэ 1859



							долларт хүрч, өмнөх 7 хоногоос 3.7 хувиар, өмнөх сараас 6 хувиар нэмэгдээд байна. Инфляц ХНБ-ны хүлээлтээс удаа дараа давснаас шалтгаалж хөрөнгө оруулагчид болон иргэдийн алт худалдан авах сонирхол нэмэгдэж алтны үнэ ийнхүү өсөв.
<b>Газрын тосны үнэ (Брент)</b>	82.6	-0.3%	2.6%	-1.2%	61.7%	88.7%	Жой Байден 2021 оны 11-р сарын 11-ний Пүрэв гарагт “АНУ-ын Засгийн газар эрчим хүчний үнэ болон инфляцыг бууруулахаар ажиллаж байна” гэсэн мэдэгдэл гаргасны дараа өчигдөр газрын тосны фьючерс үнэ 2.14 ам.доллараар буюу 2.5 хувиар унаж 82.64 ам долларт хүрэв. Харин ОПЕК+ нэгдлээс газрын тосны нийлүүлэлтийг аажмаар нэмэгдүүлэх шийдвэрээ өөрчлөхөөргүй байна.